

Нягтлан бодох бүртгэлийн сургалтын практикт тулгамдаж буй зарим асуудал

Some Issues Arising from the Practice of Accounting Education

Д. Авирмэд¹, М. Мишигдорж², Д. Лхагвасүрэн³

Хураангуй

Их дээд сургуулийн багш нарын ажлын ачааллын үзүүлэлт нь зөвхөн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх эдийн засгийн үзүүлэлт болоод зогсохгүй түүний мэргэжлийн үйл ажиллагааны чанар болон үр ашигт нөлөөлөх томоохон хүчин зүйлийн нэг болдог талаар судлаачид дурьдсан байдаг. Энэхүү судалгааны ажлын хүрээнд төрийн өмчийн зарим их дээд сургуулийн багш нарын ажлын ачааллыг холбогдох дүрэм журам, гүйцэтгэлийн үзүүлэлтүүдэд тулгуурлан тоон анализ, асуулга, ярилцлагын зэрэг уламжлалт судалгааны арга зүйг ашиглан боловсруулж нэгтгэсэн бөгөөд судалгааны үр дүнгийн мэдээлэл нь багшлах боловсон хүчний бодлого тодорхойлох, НББ-ийн сургалтын чанарыг сайжруулахтай холбоотой шийдвэр гаргалтанд ашиглагдах үндэслэлтэй мэдээлэл болно. Судалгааны үр дүнд багш нарын ачаалал их байгаа бөгөөд энэ нь суралцагч мэдлэгээ чадвар болгох, багш нар эрдэм шинжилгээ судалгааны ажлаа хийх боломжгүйд хүргэж, улмаар бүтээлч бус мэдлэгийг бий болгож байна гэж дүгнэлээ.

Түлхүүр үгс: сургалтын чанар, багшийн ажлын ачаалал, дээд боловсрол

Abstract

The workload indicators of higher education faculty are often treated merely as economic measures for evaluating teaching performance. However, existing research emphasizes that faculty workload is a major factor influencing the quality and effectiveness of academic activities, including teaching, research, and professional development. Within the framework of this study, regulations and policies related to faculty workload in higher education institutions, workload indicators, and instructional practices were examined using conventional research methods such as quantitative analysis, surveys, and interviews. The findings of the study provide valuable evidence for determining academic staff capacity, improving the quality of accounting education, and supporting informed policy and management decisions in higher education. The results indicate that faculty workloads are excessively high, which limits students' opportunities to develop competencies and practical skills, constrains academic staff's ability to engage in research and scholarly activities, and ultimately leads to fragmented and superficial learning outcomes.

Keywords: quality of education, faculty workload, academic staff, higher education

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим, Доктор (Ph.D)
E-mail: avirmedd@num.edu.mn

² МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим, Доктор (Ph.D)
E-mail: mishigdorj@num.edu.mn

³ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: dlkhagva@num.edu.mn

Удиртгал

Өнөөдөр, дэлхийн аль ч улс орнуудад их, дээд сургуулиудын багш нарын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ сургалтын чанарыг сайжруулахад анхаарах болжээ.

Монгол Улсын Засгийн газар 2000 оны эхэн үеэс эхлэн дээд боловсролын тогтолцоог бэхжүүлэх, түүнийг зохицуулах асуудалд анхаарал хандуулж эхэлсэн байна ("Монголын багш нарын VII Их хурлын шийдвэрүүд" баримт бичиг).

Олон улсын хэмжээнд болон манай улсад их, дээд сургуулийн багш нарын ажлын ачааллыг тооцож үнэлэхдээ кредит цагийн системийг ашиглаж байна.

Бид Төрийн өмчит их, дээд сургуулиудыг судалгааны объект болгон авсан. Эдгээр сургуулиудын хувьд судалгааны их сургууль болох, улмаар дэлхийн жишигт нийцсэн, шилдэг их сургууль болохоор зорилгоо тодорхойлжээ. Энэхүү зорилтод хүргэх хамгийн гол хөдөлгөгч хүч нь сургуулийн багш, сурган хүмүүжүүлэгчид бөгөөд тэдний ажлын чанар чансаагаар ирээдүйн боловсон хүчнүүдийн маань мэргэжил, мэдлэг хэмжигдэхээс гадна улс орны ирээдүй тодорхойлогдох юм.

Их, дээд сургуулиудын багш нарын ажлын ачаалал их байх тусам сургалтын чанар муу байдаг талаар судлаачид дурьджээ (Эрштейн, 2021). Иймд бид нягтлан бодох бүртгэлээр мэргэжилтэн бэлтгэдэг Төрийн өмчийн зарим их, дээд сургуулийн багш нарын ачааллыг судалж байгаа ба ингэснээр дээд боловсролын талаар бодлогын түвшинд шийдвэр гаргахад ашиглагдах үндэслэлтэй мэдээлэл бий болох юм.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэжилтэн

бэлтгэдэг их, дээд сургуулиудын өмнө тулгарч буй асуудлын нэг болох багш нарын ажлын ачааллын судалгаа хийж дүгнэлт гаргах, шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилго тавьсан болно.

Манай улсын хэмжээнд нягтлан бодогч бэлтгэж буй Төрийн өмчит МУИС, ХҮИС, ХААИС зэрэг их, дээд сургуулиуд байгаа бөгөөд төлөөлөл болгон МУИС, ХААИС-ийн багш нарын ажлын ачааллын байдалд судалгаа хийсэн. Мөн нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр багшлах боломжтой ажиллах хүчний нөөц гэж үзсэний үндсэн дээр мэргэшсэн нягтлан бодогчдоос судалгаа авч нэгтгэсэн. Судалгааны мэдээллийг Google forms, тоон анализ, асуулга, ярилцлагын зэрэг уламжлалт судалгааны арга зүйг ашиглан судалгаа авч, боловсруулж, дүгнэлт гаргасан болно.

Олон улсын жишгээр судалгааны болон сургалтын их сургуулийн багш нарын ажлын ачааллын норм ялгаатай байдаг ба энэ нь нэг талаасаа багшийг өөрийгөө хөгжүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, сургалтын материалаа шинэчлэн сайжруулах боломж бололцоогоор хангаж буй явдал бөгөөд нөгөө талаасаа суралцаж буй оюутан залууст шинэлэг, хэрэгцээтэй мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэх, өөрчлөн хувьсаж буй нийгэм, эдийн засаг, техник технологийн хөгжилтэй хөл зэрэгцэн алхах төдийгүй ажил олгогчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах томоохон хөшүүрэг болж өгдөг байна.

Судалгааны хэсэг

Манай улсын хэмжээнд нягтлан бодогч бэлтгэж буй Төрийн өмчит сургуулиудын төлөөлөл болох МУИС, ХААИС-ийн багш нарын ажлын ачааллын байдалд судалгаа хийсэн.

Дээрх хоёр сургууль багшийн ажлыг:

- Сургалтын үйл ажиллагаа,
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил,
- Бусад ажил буюу нийгмийн үйлчилгээ гэсэн үзүүлэлтээр үнэлдэг байна.

МУИС-ийн захирлын 2019 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн А/208 тоот тушаалаар баталсан “МУИС-д профессор, багш ажиллуулах журам” болон ХААИС-ийн захирлын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/86 тоот тушаалаар баталсан “ХААИС-ийн профессор багш ажиллуулах журам”-д багш нарын ажлыг дараах байдлаар нормчлон гаргасан байна (Хүснэгт 1).

Энэ хүснэгтээс харахад танхимын цаг нь тухайн сургуулиудын ирээдүйд хүрэхээр тэмүүлж буй судалгааны их сургуулиудын (өмнөх хэсэгт дурьдсан) дундаж үзүүлэлтээс их байгаа харагдаж байна. Гэвч энэ нь зөвхөн нормчилсон үзүүлэлт бөгөөд судалгаанд авч үзсэн сургуулиудын багшийн ажлын ачааллыг жилийн ногдлын гүйцэтгэлээр нь авч үзвэл дараах байдалтай байна (Хүснэгт 2).

Дээрх хүснэгтээс харахад багш нарын А цагийн болон нийт цагийн гүйцэтгэл МУИС-ийн хувьд буурсан, харин ХААИС-ийн хувьд өссөн байдалтай байна. Илүү цаг нь жилээс жилд нэмэгдэж байгаа

Хүснэгт 1. Төрийн өмчит сургуулиудын журамд заагдсан цагийн ногдол

Албан тушаалын зэрэглэл	МУИС				ХААИС		
	А цаг, кр	Танхимын цаг	Б цаг, кр	В цаг, кр	А цаг, кр	Танхимын цаг	Б, В цаг, кр
Профессор	12	256	10	4	14	304	11
Дэд профессор	13	288	8	5	15	320	10
Ахлах багш	15	320	6	5	16	352	9
Багш	16	352	5	5	17	368	8
Дадлагажигч багш	13	288	4	7	16	352	7+2

Хүснэгт 2. Багш нарын 2016-2021 оны гүйцэтгэл

Үзүүлэлт	2016-2017		2017-2018		2018-2019		2019-2020		2020-2021	
	МУИС	ХААИС	МУИС	ХААИС	МУИС	ХААИС	МУИС	ХААИС	МУИС	ХААИС
Ногдол	689.0	240.0	686.3	250.0	602.3	196.0	331.5	225.0	387.5	275.0
А цаг	384.0	202.0	386.9	168.0	342.3	119.0	240.1	147.0	277.0	180.0
Б цаг	176.0	38.0	171.4	82.0	146.5	77.0	52.7	78.0	64.0	95.0
В цаг	129.0		128.0		113.5		38.7		46.5	
Гүйцэтгэл	910.6	312.3	907.1	364.8	874.7	370.5	612.1	378.8	590.6	448.7
А цаг	461.6	251.9	457.9	241.5	444.8	249.1	407.0	262.7	388.4	293.4
Б цаг	276.8	60.4	267.1	123.3	238.2	121.4	138.6	116.1	119.7	155.3
В цаг	172.2		182.1		191.7		66.5		82.5	
Илүү бүгд цаг, %										
А цаг	1.20	1.25	1.18	1.44	1.30	2.09	1.70	1.79	1.40	1.63
Б цаг	1.57	1.59	1.56	1.50	1.63	1.58	2.63	1.49	1.87	1.63
В цаг	1.33		1.42		1.69		1.72		1.77	
1 багшид ноогдох дундаж танхимын цаг										
	378.7	447.9	375.7	515.2	395.4	590.5	361.8	622.7	414.3	569.1
Илүү цагийн хувийн жин										
А цаг	35.0	69.1	32.1	69.1	37.6	74.6	59.5	75.2	55.1	65.3
Б цаг	45.4	30.9	43.3	30.9	33.5	25.4	30.6	24.8	27.5	34.7
В цаг	19.6		24.6		28.9		9.9		17.4	

бөгөөд дунджаар 50%-иар илүү цаг хийж байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн заалтад нийцэхгүй төдийгүй багш нар зөвхөн сургалтаар зогсохгүй эрдэм шинжилгээ судалгааны ажил хийж, сургуулийн олон нийтийн арга хэмжээнд ч идэвхи санаачлагатай оролцож байгаа нь харагдаж байна.

Дэлхийн топ 500 сургуулиудын хэмжээнд хийсэн судалгаагаар эдгээр сургуулиудад нэг багшид ногдох оюутны тоо 10-14 байдаг бөгөөд судалгааны их сургуулиудад (research universities) танхимд хичээлд заадаг цаг нь жилд дунджаар 100-200, харин сургалтын их сургууль (teaching universities) буюу зөвхөн оюутнуудыг сургах үйл ажиллагаа явуулдаг их сургуулиудын хувьд танхимын цаг нь жилд дунджаар 300-400 байдаг гэсэн үр дүн гарчээ (Райчук, 2016).

Судалгаанд хамрагдсан сургуулиудын багш нарын танхимын цаг 454.5 байгаа бөгөөд энэ нь дээрх судалгааны болон сургалтын их сургуулиудын стандартаас 2.3-1.1 дахин их байгаа юм.

МУИС-ийн багш нарын А цагийн ачаалал нийт дүнгээрээ буурсан боловч илүү цагийн ачаалал тодорхой хэмжээнд байсаар байгаа нь багшлах боловсон хүчний тоотой салшгүй холбоотой бөгөөд хэдийгээр багшийн сонгон шалгаруулалт зарлаж байгаа боловч маш цөөн хүн шалгаруулалтанд орох мөн багшлах боловсон хүчний шаардлагад нийцээгүйн улмаас багшийн тоо нэмэгдэхгүй, үүнтэй холбоотойгоор үндсэн багш нартаа ачааллаа хуваарилж, зарим нэг хичээлүүд дээр цагийн багш авч ажиллуулах замаар шийдвэрлэдэг (ярилцлагын аргаар авсан судалгааны үр дүн).

Түүнчлэн багш нар сургалтын үйл ажиллагаанд ажлын цагийн 16-90%, эрдэм

шинжилгээний ажилд 10-50%, харин бусад ажилд 80 хүртэл хувийг зарцуулдаг гэжээ. Энэ нь дээрх сургуулиудын судалгаанд суурилсан их сургууль болох зорилго төдийлөн биелэгдэхгүй байгааг илтгэнэ.

Судалгаанд хамрагдсан багш нарын 57% нь МУИС, 43% нь ХААИС-ийн нягтлан бодох бүртгэлийн багш нар байлаа. Мөн 61.6% нь 16-аас дээш жил багшаар ажилласан туршлагатай хүмүүс байна. Албан тушаалын зэрэглэлийн хувьд 33.4% нь профессор, дэд профессор цолтой, үлдсэн 66.6% нь ахлах багш, багш байжээ. Эрдмийн зэргийн хувьд 38.1% нь доктор зэрэгтэй байна. Эндээс харахад нийт судалгаанд хамрагдсан багш нарын 1/3 нь доктор зэрэгтэй, профессорын албан тушаалд ажиллаж байна.

Судалгаанд хамрагдсан багш нарын 47.7% нь ажлын бус цагаар долоо хоногт ажилдаа 20 орчим цагийг зарцуулдаг гэсэн бол үлдсэн 52.3% нь 20-оос илүү цагийг зарцуулдаг ажээ (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Асуулгын судалгааны үр дүн

Үзүүлэлт	Тоогоор	Хувиар
Сургалтын үйл ажиллагаа		
50 хүртэл хувь	5	23.8%
50-75%	9	42.8%
75-аас дээш хувь	7	33.4%
Эрдэм шинжилгээний ажил		
0-10%	10	47.6%
10-20%	6	28.6%
20-30%	3	14.2%
30-50%	2	9.6%
Бусад ажил		
0-20%	15	71.2%
20-40%	4	19.2%
40-80%	2	9.6%


Багш нарын 9.5% нь 1-2 төрлийн, 76.2% нь 3-5 төрлийн, 14.3% нь 10 хүртэл төрлийн хичээлийг жилд зааж байна.

Түүнчлэн 43.1% нь 200 орчим оюутанд, 47.8% нь 200-400 оюутанд, үлдсэн 9.1% нь

400-с дээш бакалаврын түвшний оюутанд хичээл оржээ. Ахисан түвшинд хичээл заадаг 14 багшийн 21.4% нь 50-с дээш оюутанд хичээл орж байна.

Нэг хичээлийн жилд багш нарын 23.9% нь 3-аас дээш эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлдэг байна. Харин үлдсэн 76.1% нь 1-2 өгүүлэл хэвлүүлдэг ба 52.3% нь 2 хүртэл илтгэлийг эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлдэг гэжээ.

Зураг 1. Багш нарын эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэл




Багшийн ажлын үндсэн хэсгийн нэг нь оюутантай ажиллах, тэднийг удирдан чиглүүлэх явдал байдаг.

Багш нарын 56.9% нь жилд 1-3 оюутны, 33.5% нь 4-ээс дээш оюутны судалгааны ажил удирддаг бол 9.6% нь оюутны

судалгааны ажил огт удирдаагүй гэжээ.

Зураг 2. Багш нарын удирдсан оюутны тоо (1 хичээлийн жилд)



Судалгаанд хамрагдсан багш нарын 70% нь (давхардсан тоогоор) багш дутагдалтай тул ажлын ачаалал их байна гэж хариулсан байна (Зураг 3). Мөн 45% нь нэмэлт ажил хэт их тул ачааллыг нэмэгдүүлж байна гэж үзжээ.


Ачаалал ихтэй ч багш нар ажилласаар байгаагийн шалтгааныг тодруулахад дараахь хариултыг өгсөн (Зураг 4).

Багш нарын 90% нь багшийн ажилд дуртай учраас, 35% нь сургуулийн нэр хүнд, хамт олны уур амьсгал таатай, зун урт хугацаанд амардаг учраас багшаар ажилладаг гэжээ. Харин цалин сайн, нийгмийн халамж сайн гэдэг хариултыг хэн ч сонгоогүй байна.


Зураг 3. Багш нар илүү цаг гүйцэтгэж буй шалтгаан



Зураг 4. Багшийн мэргэжлээр тогтвортой ажиллаж байгаагийн шалтгаан



Зураг 5. Нягтлан бодогчдын албан тушаал, цалингийн байдал



Бид нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр багшлах боломжтой хүний нөөцийн хэсэг гэж үзсэний үндсэн дээр мэргэшсэн нягтлан бодогч нараас мөн судалгаа авч харьцуулан дүгнэлт гаргасан юм.

Судалгаанд оролцсон нягтлан бодогчдын 82.1% нь 26-45 насны, 17.9% нь 45-аас дээш насны бүлгийнхэн ба 82.1% нь эмэгтэй нябо нар бөгөөд тэдний 46.2% нь улсын секторт, үлдсэн нь хувийн секторт ажилладаг, 84.4% нь мэргэшсэн нягтлан бодогч зэрэгтэй, үлдсэн нь татварын мэргэшсэн зөвлөх, СМА нар байна. Боловсролын түвшний хувьд 61.5% нь бакалавр, 38.5% нь магистр, доктор зэрэгтэй байсан (Асуулгын судалгааны үр дүнгээс).

Судалгаанд оролцогчдын 74% нь ерөнхий болон тооцооны нягтлан бодогч буюу мэргэжлээрээ ажиллаж байгаа ба 41% нь 1 сая хүртэл, 36% нь 1.8-3.4 сая төгрөгийн цалинтай байна.

Нягтлан бодогчийн мэргэжлээр ажиллаж буй шалтгааныг тодруулахад одоогийн ажлаа сонгоход нөлөөлсөн хүчин зүйлд хамгийн их буюу 29.4% нь карьер өсөлт, 23.5% нь байгууллагын нэр хүнд, 17.6% нь цалингийн хэмжээ, 14.7% нь нийгмийн хангамж, бусад урамшуулал (Зураг 6) гэжээ.

Нягтлан бодогч нарт багшлах санал тавьбал хэрхэн хүлээж авахыг тодруулахад нягтлан бодогчдын ихэнх нь буюу 71.1% нь үгүй гэсэн байна. Энэ шийдвэрт

Зураг 6. Нягтлан бодогч мэргэжлээр тогтвортой ажиллаж буй шалтгаан



нөлөөлсөн зүйлсийг тодруулах зорилгоор лавлаж асуухад дараахь хариултуудыг өгсөн. Үүнд:

- саналыг сонсоно,
- мэдлэг, туршлагаа хойч үедээ түгээнэ, өөрийгөө сорино,
- би ясны хичээл муу заадаг,
- нягтлан гэдэг мэргэжлийг курсаар олгоод байгаа учир нэр хүндгүй байна. Яагаад сургуульд нь сурах ёстойг харуулах,
- багшаар мэргэшээгүй,
- багшлах сонирхолгүй,
- дуртайяа хүлээн авна, ялангуяа төгсөж байгаа оюутнуудад практик хэрэгтэй гэж боддог,
- татгалзана, хөдөө амьдрах УБ-д амьдрахаас илүү амар.

Дээрх хариултуудаас харахад нягтлан бодогч нар мэргэжлийн чиглэлээр багшлах талаар шийдвэр гаргаж буй хоёр хандлага ажиглагдлаа. Тухайлбал:

1. Багшлах нь мэдлэгээ хойч үедээ заах, өөрийгөө хөгжүүлэх, сорих нь сайхан боловч суралцахад их цаг зарцуулдаг, цалин бага, багшлах эрхийн ямар нэгэн сургалтанд хамрагдаагүй зэрэг шалтгаанаар сонгоогүй.
2. Багшлах дургүй, татгалзана, огт сонирхдоггүй зэрэг хариултыг өгчээ.

Ийнхүү мэргэжлийн нягтлан бодогчид багшийн сонгон шалгаруулалтанд оролцдоггүй нь багшийн дутагдал үүсэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг нь харагдаж байна.

Хэлэлцүүлэг

Олон улсын түвшинд их дээд сургуулийн багш нарын ачаалал их байгаагаас дараахь сөрөг үр дагавар бий болно гэж үздэг ба манай практикт ч бодитоор нүүрлэж байна. Үүнд:

- Зөвхөн танхимаар хичээллэх нь мэдлэгийг чадвар болгоход сөргөөр нөлөөлдөг.
- Хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт, мэдлэг чадварын шаардлагыг хангах хэмжээнд өөрчлөгдөж чадахгүй
- Суралцагч өөрсдөө мэдлэг олж авах чадвар эзэмшээгүйгээс багш нар мэдээллийг дамжуулах үүрэг гүйцэтгэж, улмаар багшийн танхимын цагийн ачааллыг улам нэмэгдүүлж байна.
- Тэтгэврийн насны багш нар хэдийгээр ажиллах боломжтой байсан ч тэднийг ажлаас халж байгаа нь зөв шийдэл биш бөгөөд нэг талаас ажлаа алдсан багш нар, нөгөө талаас ачаалал ихтэй болсон багш нарын аль алинд нь сөрөг байна.

- Танхимын ачаалал их байснаар багш нар судалгааны ажлаа гүйцэтгэх хугацаа багасч, улмаар судалгааны сургууль болох зорилгын биелэлтэд сөргөөр нөлөөлнө.

Багш нарын ачааллын асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа олон улсын туршлагыг авч үзвэл:

- Хичээлийн явцад оюутнуудаараа судалгаа хийлгэх байдлаар шийдэх арга замыг дэлхийн улс орнуудад ашигладаг
- Зарим сургуульд судалгааны чиглэлээр дагнасан ажилтнуудыг ажиллуулдаг. Багш зөвхөн хичээлээ заадаг.
- Техник технологийн хурдацтай хөгжил нь ажил мэргэжлийн хувьд хоцрогдолд орж, дахиад шинэ мэргэжлийн хэрэгцээ шаардлагыг үүсгэж байна. Иймд суралцагч өөрсдөө шинэ мэдлэг олж авах чадвар шаардаж байна.

Дүгнэлт

Энэхүү өгүүллийн хүрээнд хийсэн судалгааг нэгтгэн үзвэл:

- Төрийн өмчит их дээд сургуулиудын багшлах боловсон хүчин хүрэлцээгүйн улмаас багш нар хэт ачаалалтай ажиллаж байна. Ачааллыг их дээд сургуулиудын сургалтын журамд тусгасан нормт хэмжээнд байлгах, цаашлаад дэлхийн топ их дээд сургуулийн жишигт ойртуулах нь зүйтэй. Үүний тулд багшийн цалин хангамжийг

нэмэгдүүлэх, ажлын үнэлэмжийг өсгөх шаардлагатай байна.

- Их дээд сургуульд багшлах нь багш өөрөө суралцах болон карьер өсөлтөнд багагүй хугацаа зарцуулдаг, цаг завгүй, хөдөлмөрийн үнэлэмж бага гэдгийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрдөг гэж дүгнэж болохоор байна.
- Багш нарын ажлын ачаалал хэт их байх нь нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулиудын хувьд оюутнуудад өгөх мэдээлэл мэдлэг нэгэн хэвийн, хуучинсаг технологийн шинэ эрин үеийн дэвшилт, дэлхийн чиг хандлага хийгээд практикт тулгараад буй асуудлуудаас хол хөндий болж бэлтгэгдэн гарч буй мэргэжилтнүүдийн хөдөлмөрийн зах зээл дээрх өрсөлдөх чадварыг буруулах магадлалтай хэмээн судлаачдын зүгээс дүгнэлээ.

Зөвлөмж

Бүхий л их дээд сургуулийн удирдлагууд төдийгүй боловсролын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагууд одоогийн үүсээд байгаа нөхцөл байдлын талаар ирээдүйд чиглэсэн алсын хараатай бодлого боловсруулах, бүтээлчээр хэрэгжүүлэх шаардлагатай байна. Эс тэгвээс бол боловсролын систем зөв голдирлоор хөгжиж чадахгүйд хүрч, улмаар улс орны тусгаар тогтнолд сөргөөр нөлөөлнө. Боловсролтой иргэд улс орны ирээдүй байдаг.

Ашигласан материал

- Razalli, A. R., Kamarudding, K., Ong, E. T., Teck, W. K., & Ein, N. (2021). Evaluating Teaching Workload of Academic Staff for Optimum and Effective Use of Expertise Resources. *International Journal of Academic Research in Business and Social Sciences*, 11(6), 13-26. <https://doi.org/10.6007/IJARBSS/v11-i6/10077>
- Ujir, H., Salleh, S. F., Marzuki, A. S. W., Hashim, H. F., & Alias, A. A. (2020). Teaching Workload in 21st Century Higher Education Learning Setting. *International Journal of Evaluation and Research in Education*, 9(1), 221-227. <https://doi.org/10.11591/ijere.v9i1.20419>
- Абдеев, Р. Ф. (1994). *Философия информационной цивилизации*. Москва: Владос.
- Монголын багш нарын VII Их хурлын шийдвэрүүд
- Райчук, Д. Ю. (2016). Аудиторная нагрузка ППС в свете мирового опыта. *Высшее образование в России*, 1(197), 105-112.
- Эрштейн, Л. Б. (2021). Чрезмерная Нагрузка Преподавателей Вузов Как Фактор Разрушения Высшего Образования в России. *Социально-экономические науки*, 2, 75-87. <http://doi.org/10.15593/2224-9354/2021.2.6>